

АРИГ БАНК
“АНДЕРРАЙТЕРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ”-ЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: АНДЕРРАЙТЕРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ

Төслийн дугаар: АРИГ/20241015

УЛААНБААТАР ХОТ

2024

Нэг. ТЕНДЕРИЙН УРИЛГА

Ариг банк нь тендерт оролцох сонирхолтой байгууллагуудыг АРИГ/20241015 тоот “АНДЕРРАЙТЕРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ” тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь Ариг банкны веб сайт, социал хаягаар зарлагдаж байгаа тул <https://www.arigbank.mn> эсвэл <https://www.facebook.com/ArigBankMN> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Үнийн саналыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 17 цаг 00 минутаас өмнө ХУД, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө гудамж, 26 тоот барилга, 14 давхар, 1401 тоот хаягт байрлах Ариг банкны төв байранд битүүмжилсэн хэлбэрээр ирүүлсэн байна.

Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг

Улаанбаатар, Монгол улс, Утас: 80117616

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
- 1.1. Тендерт оролцогч нь Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Нийтийн мэдээллийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
- 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- а) Үнийн санал;
 - б) Тусгай зөвшөөрөл /Хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажсан хуулбар/;
 - в) Чадварын мэдээлэл /хүний нөөцийн ур чадвар, туршлагын мэдээлэл/;
 - г) Санхүүгийн чадавхи;
 - д) Ажил гүйцэтгэх график;
- 4. Тогтмол үнэ**
- 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 4.2. Бүх нэр төрлийн ажлыг үнэлсэн байна. Аль нэг төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй бол түүнийг бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 5.1. Нэвтрүүлэх үйлчилгээ нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**7. Санал болгосон
үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө цахим шуудангаар мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Захиалагч: Ариг банк Үнэлгээний арга: Харьцуулалт</p> <p>Тендерт оролцогч дараах материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх Андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсныг нотлох баримт, хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар 2. Удирдлагын багийн танилцуулга, мэргэжлийн диплом, сертификат, үнэмлэх хавсаргах 3. Санхүүгийн татварт баталгаажсан тайлан, сүүлийн 2 жил, 2 жилээс богино хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол ажилласан хугацааны тайлан 4. Үнэт цаас гаргахтай холбоотой хийгдэх ажлын төлөвлөгөө ирүүлэх 5. Үйлчилгээний дэлгэрэнгүй үнийн санал болон холбогдох шимтгэлүүд 6. Бондын купон болон хугацааны судалгаа, санал 7. Бонд гаргах боломжит хэмжээ /Хэмжээг баталгаажуулах баримттай байвал давуу тал болно/ 8. Өмнөх ижил төстэй хийж гүйцэтгэсэн ажлын туршлагын мэдээлэл
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: ХУД, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө гудамж, 26 тоот барилга, 14 давхар, 1401 тоот хаягт байрлах Ариг банкны төв байранд битүүмжилсэн хэлбэрээр ирүүлсэн байна.</p> <p>Огноо: 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цаг: 17 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Ариг банк Огноо: 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор</p>